


ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ

Цагаандэлгэр сум

2019.05.25

№	д/д	Шийдвэрийн нэр, огноо, дугаар	Холбогдох заалтын агуулга	Хэрэгжилтын явц, өөрийн үнэлгээ	Хэрэгжилтийн хувь
ЗГ-ын тогтоол					
01	1	Төрийн албаны сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай 2018-08-22 Дугаар 2018_258	1.. Дараах арга хэмжээ авч ажиллахыг Засгийн газрын гишүүд, бүх шатны Засаг дарга, Засгийн газрын агентлагийн дарга, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дарга нарт үүрэг болгосугай: 1.1. харьяа байгууллага болон салбар, нэгжид сахилга, дэг журмыг сахиулах тодорхой арга хэмжээ авч, төрийн албаны хууль тогтоомж, холбогдох дүрэм, журмыг зөрчсөн төрийн албан хаагчид хариуцлага тооцож тухай бүр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт тайлагнаж байх;	Засгийн газраас төрийн албаны сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай 258 тогтоолыг баталж төрийн байгууллагууд төрийн албаны сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах талаар ажлын төлөвлөгөө гарган биелэлтэд нь хяналт тавин ажиллаж байна. 2019 онд ИТХ-2, ЗДТГ-т 19, ЕБС-д 25, Соёлын төв 5, хүүхдийн цэцэрлэг 11, ЭМТ 16 нийт 74 төрийн албан хаагч ажиллаж байна. 2019 оны 5 дугаар сарын байдлаар төрийн албаны хууль болон холбогдох дүрэм, журмыг зөрчсөн 2 албан хаагчид хариуцлага тооцсон.	70
	2		1.3. төрийн албан хаагчдын ажлын байрны шинжилгээ хийж, шинжилгээний дүнд тулгуурлан байгууллагын чиг үүргийн давхардал, хийдлийг арилгаж, ажлын бүтээмж, үйл ажиллагааны уялдаа холбоог сайжруулах;	Төрийн албаны тухай хууль 2019.01.01-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан төрийн захиргааны албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтыг ТАЗ-ийн 2019 оны 3 дугаар тогтоолын дагуу шинэчлэн боловсруулах ажлын хүрээнд 6 төрийн жинхэнэ албан хаагчийн ажлын бүтээмж, үйл ажиллагааны уялдаа холбоог сайжруулахад анхаарч ажлын байрны шинжилгээ хийж асуулга ярилцлага хийсэн. ЗДТГ, ЭМТ-ийн албан хаагчдын ажлын байрны хийдлийг арилгаж, ажлын бүтээмжийг дээшлүүлэх зорилгоор хурууны хээгээр цаг бүртгэж давхар цагийн бүртгэлийн дэвтрээр хяналт тавьж ажиллаж байгаа ба ЕБС, Соёлын төв, хүүхдийн цэцэрлэг хурууны хээгээр цаг бүртгэх төхөөрөмж авч суурилуулахад бэлэн болгоод байна. Багш ажилчдын ажлын цагийн бүртгэлийн	100

				дэвтэр гарган өдөр бүр багш ажилчид төлөвлөгөө гарган 7 хоногт хийсэн ажлаа хэлэлцэж ажиллаж байна. Мөн сумын төрийн байгууллагуудын үйл ажиллагааны уялдаа холбоог сайжруулж үйл ажиллагааг давхардуулахгүйгээр явуулах зорилгоор 2019 онд зохион байгуулах үйл ажиллагааны нэгдсэн төлөвлөгөөг Засаг даргаар батлуулан ажиллаж байна. ЭМТ-өөс сар бүр эмч ажилчдаас шинэ бүтээл оновчтой санааны хэрэгжилтийг авч, ажилд тусган ажиллаж байна. Төрийн албан хаагчдын ажлын бүтээмжийг дээшлүүлэхэд анхаарч тэдний ажиллах орчны таатай нөхцлийг нэмэгдүүлэх зорилгоор ЭМТ хуучин галлагааны өрөө, үүдний коридор хэсгийг засварлаж, ЗДТГ-ын дээвэр засвар зарим өрөөнүүдэд засварын ажлыг эхлүүлээд байна.	
2	3	2019 оныг “Иргэн төвтэй төрийн үйлчилгээний жил” болгох тухай 2019-01-16	3. Хавсралтаар төлөвлөгөөг оруулав.. “Иргэн төвтэй төрийн үйлчилгээний жил”-ийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээг эрхлэх ажлын хүрээ, харьяа нутаг дэвсгэртээ зохион байгуулж, ажлын тайланг улирал тутам Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт ирүүлж байхыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай. Жич: Хавсралтаар оруулсан	“Иргэн төвтэй төрийн үйлчилгээний жил”-ийн хүрээнд хийж хэрэгжүүлэх 21 заалт бүхий төлөвлөгөөг 2019.04.17-ны өдөр Засаг даргаар батлуулан бусад төсвийн байгууллагууд болон албан хаагчдад танилцуулж хэрэгжилтийг хяналтандаа аван ажиллаж байна.	40



		Дугаар 2019_23	“ИРГЭН ТӨВТЭЙ ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЖИЛ”-ИЙН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ-ний дагуу өөрийн нэр заасан ажлыг хүснэгтээр гаргаж тайлагнана.		
3	4	Дүрэм батлах тухай 2019-01-23 Дугаар 2019_33	2. Байгууллагын дотоод журмыг энэ тогтоолоор баталсан дүрэмд нийцүүлэн баталж, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллахыг төсвийн шууд захирагч нарт даалгасугай.	ЗГ-ын 2019 оны 33 дугаар тогтоолоор баталсан Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрмийг албан хаагчдад танилцуулж дотоод журамд тусган төрийн албан хаагчидтай ёс зүйн гэрээ байгуусан. Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчдын ёс зүйн дүрмийг мөрдөж ажиллах талаар байгууллагууд хамт олны хурлаар хэлэлцэж зарим өөрчлөлтүүдийг нэмж тусгасан. Тухайлбал ЭМТ-ийн даргын тушаалаар ЭМТ-ийн дотоод журмын 8-р бүлэгт 3 заалт, ЕБС-ийн дотоод журмын 5-р бүлэгт 4 заалт нэмэлтээр тус тус оруулсан.	70
ЗГ-ын хуралдааны тэмдэглэл					
4	5	2019 оны 1 дүгээр сарын 16-ны өдөр 3 дугаар тэмдэглэл 2019-01-16 Дугаар 2019_3	I.. Монгол Улсын Засгийн газраас зарласан “Хариуцлагын жил”-ийн хүрээнд зохион байгуулсан ажлын тайланг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Г.Занданшатар Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан дараахь арга хэмжээ авч ажиллахыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгав: 1. Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2019 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах худалдан авах ажиллагааг хуулийн дагуу төлөвлөгөө гарган, шилэн дансанд байршуулах замаар 2019 оны I улиралд багтаан олон	1. Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2019 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд нийт 115,945,300 төгрөгний 12 бараа, ажил, үйлчилгээг тусган хуулийн дагуу сумын Засаг даргаар батлуулан байгууллагын мэдээллийн самбар болон шилэн дансанд байршуулсан. 2019 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг Мэдээллийн цагаар танилцуулж 30 гаруй иргэд төрийн албан хаагчид хамрагдсан. 2019 оны 5 сарын байдлаар сумын ОНХС-ийн хөрөнгөөр худалдан авах ажиллагаа явагдаагүй байна. 2019 оны сургууль, цэцэрлэгийн хүүхдийн хоол хүнсний нийлүүлэгчийг шалгаруулах цахим тендер зарласан боловч цахим тендерт материал ирүүлсэн компани байгаагүй учир шууд гэрээ байгуулах зөвлөмж өгч Сирина ХХК-тай гэрээ байгуулан сургууль цэцэрлэгийн хүүхдийн хүнсний материалыг нийлүүлж байна.	70

6	нийтэд ил тод, шуурхай зохион байгуулах; 2. Төрийн болон нутгийн удирдлагын бүх шатны байгууллагууд баталсан дүрэм, журамдаа шинжилгээ хийж, иргэд, олон нийтээр хэлэлцүүлэн, байгууллага, иргэдэд хүнд суртал, чирэгдэл үүсгэж байгаа дүрэм, журмыг хүчингүй болгох арга хэмжээ авч, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт мэдээг хагас, бүтэн жилээр ирүүлэх; 3. Төрийн байгууллагад иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд нь шийдвэрлээгүй төрийн албан хаагч, албан тушаалтанд хариуцлага тооцож, өргөдөл гомдол шийдвэрлэлтийн мэдээнд тусгаж байх; 4. Төрийн албан хаагч ажлын болон ажлын бус цагаар ажлын байр, томилолтын явцад согтууруулах ундаа хэрэглэхийг хориглох талаар тогтоосон дэг журмыг чанд мөрдүүлэх, журмыг зөрчсөн албан хаагчтай тухай бүр холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага тооцож байх; 5. Яам, агентлагийн бодлого, шийдвэрийг бусад байгууллага болон олон нийтэд ил тод мэдээлэх, тусгай зөвшөөрөл олгох ажлыг цахимжуулах арга хэмжээ авах; 6. Төрийн байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд нийцүүлэн төрийн албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөг сар бүр дүгнэж ажиллах; 7. Төрийн бүх шатны байгууллагын салбар, нэгжийн ажлын уялдаа, бүтээмжийн үнэлгээг тодорхой болгох; 8. Төрийн албан хаагчдад гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх сургалт, сурталчилгааг хууль хяналтын байгууллагатай хамтран зохион байгуулах, хууль зөрчсөн албан	2. 2019 оны 5 сарын байдлаар ЗДТГ-аас иргэд олон нийтээр хэлэлцүүлж баталсан дүрэм, журам гараагүй байна. Төрийн албаны тухай хуулийг 2019 оны 01-р сарын 01-ны өдрөөс мөрдөж эхэлсэнтэй холбогдуулж хүүхдийн цэцэрлэгийн дүрэм шинэчлэгдэн батлагдсан учраас эрхлэгчийн Б/17 тушаалаар цэцэрлэгийн хуучин дүрмийг хүчингүй болгож шинээр болосвруулах ажлын хэсгийг байгуулсан.	70
		3. Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтнуудад хандаж ирүүлсэн санал, өргөдөл, гомдлын бүртгэн авч холбогдох албан хаагчдад өгч шийдвэрлүүлэн хуулийн хугацаанд хариуг өгч ажиллаж хэвшсэн. Төрийн байгууллага, багийн Засаг дарга нар, албан хаагчдад ирүүлсэн СӨГ-ын хэрэгжилтийг улирал тутам ЗДТГ-ын бичиг хэргийн эрхлэгч нэгтгэн аймгийн ЗДТГ-т мэдээлдэг. Засаг даргын Тамгын газрын СӨГомдол хүлээн авах утас 88601360 нээлттэй утсыг ажиллуулж байна. 2019 оны 05 сарын эцсийн байдлаар нийт 95 санал хүсэлт, өргөдөл ирснийг хүлээн авч бүртгэн холбогдох албан тушаалтанд хяналтын картаар хяналт тавьж СӨГ-ийг 100% буюу 95 СӨГ-ийг хуулийн хугацаанд нь шийдвэрлэн, иргэдэд хариуг цаасаар болон утсаар, биеэр уулзаж хариуг өгч ажиллалаа.	100
		4. Төрийн албан хаагчдыг ажлын болон ажлын бус цагаар ажлын байр, томилолтын явцад согтууруудах ундаа хэрэглэхийг хориглох тухай заалтыг байгууллагын дотоод журмын 6.4.4, 6.4.5-д нэмэлтээр тусган баталж чанд мөрдөж ажиллах талаар албан хаагчдад үүрэг болгож ажилласан ба	100

	7	хаагчдад заавал хариуцлага тооцож байх; 9. Төрийн захиргааны болон нутгийн удирдлагын байгууллагын ажлын үр дүнг иргэдийн сэтгэл ханамжийн үзүүлэлттэй холбон дүгнэх үнэлгээний журам тогтоох.	согтууруулах ундаа хэрэглэж тогтоосон дэг журмыг зөрчиж хариуцлага тооцуулсан албан хаагч байхгүй болно.	
			5. Засгийн газар болон яамдын сайдын тушаал болон бусад дээд газрын шийдвэрийг бусад байгууллага болон олон нийтэд ил тод мэдээлж мэдээллийн самбар, цахим хуудсаар сурталчилж байна.	100
			6. ЗДТГ-ын 2019 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг баталж түүнд нийцүүлж төрийн албан хаагчид гүйцэтгэлийн төлөвлөгөө батлуулж сар бүр хэрэгжилтийг дүгнүүлж ажиллаж байна.	100
			7. Мөн сумын төрийн байгууллагуудын үйл ажиллагааны уялдаа холбоог сайжруулж үйл ажиллагааг давхардуулахгүйгээр явуулах зорилгоор 2019 онд зохион байгуулах үйл ажиллагааны нэгдсэн төлөвлөгөөг Засаг даргаар батлуулан ажиллаж байна. Төрийн байгууллагууд мэдээллийн ил тодын самбарыг тогтмол ажиллуулж мэдээд мэдээллийг цаг тухай бүр мэдээлж ажиллалаа. Иргэдээс өгч буй хандивийн мэдээлэл түүний зарцуулалтыг иргэд албан хаагчдад ил тод болгосон.	70
			8. Байгууллагын албан хаагчдыг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор дотоод журамд энэ талаарх заалтуудыг орууллаа. Архигүй аймаг Дундговь дэд хөтөлбөрийн хүрээнд арх согтууруулах ундааны хэрэглээг бууруулах, хорт зуршлаас сэргийлэх, эрүүл зан үйлийг төлөвшүүлэхэд зорилгоор албан хаагчдын дунд Архидалтгүй сум Цагаандэлгэр сэдэвт хэлэлцүүлэг зохион байгуулсан.	70
			9. ЕБС-аас анги бүр эцэг эхийн хурлыг улиралд 2 удаа хийж боловсролын үйлчилгээг түргэн шуурхай хүргэж эцэг, эхийн санал хүсэлтийг хүлээж авдаг. Нийт эцэг эхээс санал асуулга авч цаашдын үйл ажиллагаандаа анхаарч ажилладаг. 2018-2019 оны хичээлийн жилийн эцэг эхчүүдийн сэтгэл	70

			ханамжийн судалгаанд нийт 65 хүн хамрагдсан байна. Соёлын төвийн албан хаагчдаас ажлын байрны сэтгэл ханамжийн судалгааг 1 удаа авч ажлын чиг үүргийг тэнцүүлсэн.	
8		II.. Төрийн жинхэнэ албан хаагчийн үйл ажиллагаа, мэргэшлийн түвшинг үнэлэх ажлыг улсын хэмжээнд зохион байгуулсан дүнг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Г.Занданшатар Засгийн газрын гишүүдэд танилцуулав. 1.9. Төрийн албаны тухай хууль, холбогдох журамд заасны дагуу төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн үнэлгээг бодитой, үнэн зөв үнэлэх, үнэлгээний дагуу цалин урамшуулал, хариуцлагын асуудлыг хууль, дүрэм, журамд нийцүүлэн хэрэгжүүлж байх; 1.10. төрийн захиргааны болон нутгийн захиргааны байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг бодлогын баримт бичигтэй уялдуулах, хагас, бүтэн жилээр явцын хяналт-шинжилгээ хийж үр дүнг албан хаагчдад тогтмол мэдээлж байх; 1.11. төрийн албан хаагчийн сахилга хариуцлагыг дээшлүүлэн байгууллага, нутаг дэвсгэртээ хууль хэлбэрэлтгүй хэрэгждэг соёлыг тогтоож иргэдийн итгэлийг хүлээсэн, ил тод, хариуцлагатай төрийн албыг төлөвшүүлэх чиглэлээр өөрийн эрх хэмжээний хүрээнд үр дүнтэй арга хэмжээг зохион байгуулж хэвшүүлэх.	1.9. ЗДТГ-аас төрийн захиргааны албан хаагчдаас гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг сар бүр дүгнэж байна. Төрийн үйлчилгээний албан хаагчдын ажлыг сар бүр дүгнэж ур чадварын нэмэгдлийг 3 албан хаагчид олгож ажиллаж байна. ЭМТ-өөс эмч ажилчдын сарын ажлын тайланг дараа сарын эхний 3 өдрийн дотор авч, ажлыг дүгнэж, урамшууллын системээр урамшуулал олгож ажиллаж байна. Сарын эхний 3 хоногт багтан тайлангаа өгөөгүй эмч ажилчдын сарын ажлыг “0” оноогоор дүгнэж байгаа нь хариуцлагын тогтолцооны нэг шалгуур болж байна. ЕБС-аас бүх багш ажилчдын улирлын үр дүнгийн урамшууллыг тайлан хамгаалалт хэлбэрээр хэлэлцүүлэн дүгнэж 1,3-р улирлын ажлыг өөрийн үнэлгээгээр, 2,4-р улирлын ажлыг байгууллагын хөндлөнгийн үнэлгээгээр дүгнэж үр дүнгийн урамшууллыг олгодог.	100
			1.10. ЗДТГ-ын 2019 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, сумын эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэл төлөвлөгөөтэй уялдуулан боловсруулж батлуулсан.	70
			1.11. Төрийн албан хаагчийн сахилга хариуцлагыг дээшлүүлэх талаар гарсан ЗГ-ын тогтоол бусад шийдвэрүүдийг тухай бүр албан хаагчдад тусгаж зарим заалтыг байгууллагын дотоод журамд тусгаж ажиллаж байна. Ажлын цагийг баримталж иргэдэд хүнд сурталгүй түргэн шуурхай төрийн үйлчилгээг хүргэж байна. Соёлын төвөөс албан хаагчдын сахилга хариуцлагийг дээшлүүлэх зорилгоор “ШАР БОЛОН УЛААН КАРТ” аяныг өрнүүлэн ажиллаж байна. /Шар карт –	100

				амжилттай сайн, Улаан карт- хангалтгүй муу гэсэн үнэлгээтэй байна/. Шалгуурыг улирал бүр дүгнэж ажиллаж байна.	
ЗГ-ын албан даалгавар					
5	9	Сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай 2017-10-26 Дугаар 2017_01	2.. Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт: 2.1. Албан тушаалтны сахилга, хариуцлагыг өндөржүүлж, аливаа ажил, асуудлыг цаг алдалгүй шуурхай зохион байгуулж гүйцэтгэлийн явц, үр дүнд тавих хяналтыг сайжруулан хүлээлгэх хариуцлагыг чангатгаж, төрийн албаны стандартыг мөрдүүлж ажиллах;	Төрийн байгууллагын удирдлагууд болон төрийн албан хаагчдад өдөр тутмын үйл ажиллагаандаа сахилга хариуцлагатай хандаж аливаа асуудлыг шуурхай зохион байгуулж байх талаар үүрэг чиглэл өгч албан хаагчдын ажлын хариуцлагыг нэмэгдүүлэхэд анхаарч санаачлагатай ажиллахыг шаардаж байна.	70
	10		1.4. Төрийн албаны үр ашгийг сайжруулах: Ажилтан, албан хаагчдын цаг ашиглалт, ажлын бүтээмжийг сайжруулах, үүрэгт ажлаа чанартай, үр дүнтэй хийж гүйцэтгэх, ажлын байрны дэг журмыг чанд сахих;	Төрийн байгууллагууд ажилтан албан хаагчдын ажлын цаг ашиглалт, ажлын бүтээмжийг сайжруулах, ажлын байрны дэг журмыг сахиулахад анхаарч хурууны хээгээр цаг бүртгэхээс гадна бүртгэлийн дэвтрээр давхар хяналт тавьж ажлаас хоцорсон цаг минутыг тооцож, 8 цагийн таслалт болоход нь ажлын нэг өдрийн цалин хасч ажиллаж байна. Гадуур ажиллах хуудас, гадуур ажиллах ажлын дэвтэр зэргийг хөтөлж байна.	70
	11		2.4. Хууль тогтоомж зөрчсөн, зөрчил, дутагдал гаргасан, ажлаа цалгардуулсан албан тушаалтанд холбогдох хуулийн дагуу тухай бүр нь хариуцлага тооцож, зохих байгууллага, албан тушаалтанд мэдээлж байх;	ЭМТ-өөс ажил цалгардуулж ажлын цаг тасалсан, ёс зүйн гомдол ирсэн 2 албан хаагчийг удирдлагын багаар хэлэлцэн хууль тогтоомжийн дагуу сануулах арга хэмжээ авч цаашид алдаа дутагдал гаргахгүй байх талаар үүрэг даалгавар өгч ажилласан.	100
ХЭРЭГЖИЛТИЙН ХУВЬ					81%

ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР